

**АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛСЫН СИДНЕЙ ХОТ, ХОЛБООНЫ БҮГД  
НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ФРАНКФУРТ ХОТНОО МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР НЭЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ АСУУДЛЫГ  
ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр Ерөнхий консулын газар нээхэд шаардагдах төсөв болон гадаад улсад амьдарч буй монгол хүүхдүүдэд монгол хэл, бичиг, ёс заншлыг мартуулахгүй дэмжих бодлогын хүрээнд консулын газраас хэрэгжүүлэх арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан дээрх хотуудад суралцаж, хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэдийн тоон мэдээллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир Ерөнхий консулын газар нээх болсон хэрэгцээ шаардлага, цаашид дипломат төлөөлөгчийн газар нээхээр төлөвлөж байгаа улс, хотын мэдээлэл болон төсөвт тусгагдсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар шинээр консулын газар нээхэд баримталдаг шалгуур үзүүлэлт, үнэлгээ байдаг эсэх, талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Засгийн газраас зөвшилцөхөөр ирүүлсэн Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудал тус бүрээр санал хураалт явуулж, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**